

ПентаСудоку

1	1	3	5	1
3	3	2	0	3
3	0	3	2	3
1	4	0	3	3
3	3	3	1	1

Дээрх хүснэгтийн мөр, багана болон хоёр диагональ дагуу уншихад үүсэх таван оронтой тоонууд анхны тоо байна. Мөрийг зүүнээс баруун тийш уншина. Баганыг дээрээс доош нь уншина. Гол диагоналийг зүүн дээд булангаас баруун доод булан руу уншина. Хажуугийн диагоналийг зүүн доод булангаас баруун дээд булан руу уншина. Доорх нөхцлийг хангах ийм квадратуудын тоог олох програм бичнэ үү:

- Анхны тоонуудын цифрүүдийн нийлбэр өгсөн тоотой тэнцүү байна (дээрх хүснэгтийн хувьд нийлбэр нь 11 байна)
- Зүүн дээд буланд байх цифрийг урьдчилан өгнө (1 гэж өгсөн байна)
- Нэг анхны тоо хэд дахин хэрэглэгдэж болно
- Тоо нь 00002 гэх мэт тэгээр эхэлж болохгүй

Оролт

Эхний мөрөнд анхны тоонуудын цифрүүдийн нийлбэр хэд байх ёстойг заах натурал тоо байна.

Дараагийн мөрөнд квадратын зүүн дээд буланд байх цифр өгөгдөнө.

Өгөгдсөн тохиолдол бүрт дор хаяж нэг квадрат оршин байна.

Гаралт

Өгөгдсөн нөхцөлд таарах квадратуудын тоог хэвлэнэ.

Жишээ оролт

11

1

Жишээ гаралт

3

